



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/104

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол улсын “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.7 дахь заалт, тус газрын Арга зүйн зөвлөлийн 2023 оны 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ус, цаг агаар, байгаль орчны аюултай үзэгдлийн мэдээлэл солилцооны FM-10-02 АYUUL код болон аюултай үзэгдлийг мэдээлэх заавар” /ШЗ.VIII.01.01.2023/-ыг хавсралтаар баталсугай.

2. “Ус, цаг агаар, байгаль орчны аюултай үзэгдлийн мэдээлэл солилцооны FM-10-02 АYUUL код болон аюултай үзэгдлийг мэдээлэх заавар”-ыг хэвлүүлж, 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний өртөө, харуулд мөрдүүлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтэс /Д.Уламбаяр/ болон Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ заавар гарсантай холбогдуулан 1998 онд хэвлэгдсэн “Ус, цаг агаар, байгаль орчны аюултай үзэгдлийг мэдээлэх заавар IY дэвтэр (Здахь хэвлэл)”, 2008 онд хэвлэгдсэн “Цаг уур, орчны хяналт шинжилгээний заавар. ШЗ.II.06.04.2008. Ус, цаг агаар, байгаль орчны аюултай үзэгдлийг мэдээлэх заавар IY дэвтэр (4 дэх хэвлэл), 2001 оны “Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлын заавар /ШЗ.VIII.01.2001/ “Цаг уурын аюултай үзэгдлийн мэдээ солилцооны “FM-10-02 АYUUL” код”, 2002 оны “Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний заавар ШЗ.VIII.03.02. Ус, цаг агаар, байгаль орчны аюултай үзэгдлийн мэдээлэл солилцооны “FM-10-02 АYUUL код”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ЭНХТҮВШИН

151230402

d:\2023\а тушаал\06.13-104.docx

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын
2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн
А/104 дүгээр тушаалын хавсралт



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**



**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ЗААВАР
ШЗ.ҮИИ.01.01.2023**

Ус, цаг агаар, байгаль орчны аюултай үзэгдлийн мэдээлэл солилцооны "FM-10-02
AYUUL" код болон аюултай үзэгдлийг мэдээлэх заавар

(Нэгтгэсэн хэвлэл)

Улаанбаатар хот
2023 он

ГАРЧИГ

О Р Ш И Л	5
Цаг агаарын аюултай болон байгалийн гамшигт үзэгдлийн тухай	6
мэдээний үндсэн ойлголт	6
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ	7
Ус, цаг агаар, байгаль орчны аюултай үзэгдлийн мэдээлэл солилцооны	7
“FM-10-02 АҮУУЛ” код	7
КОДЫН БҮТЦИЙН ТАЙЛБАР	8
КОДЛОХ ДҮРЭМ	9
“FM-10-02 АҮУУЛ” КОДЫН ТОМЬЁОЛСОН ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ НЭР,	10
ХЭРЭГЛЭХ ТАЙЛБАР	10
ХОЁРДУГААР ХЭСЭГ	16
УС, ЦАГ АГААР, БАЙГАЛЬ ОРЧНЫ АЮУЛТАЙ ҮЗЭГДЛИЙГ МЭДЭЭЛЭХ ЗААВАР	16
ЖИШЭЭ 1: Үзэгдэл эхэлсэн тухайд нь мэдээлэх цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээ:	16
ЖИШЭЭ 2: Үзэгдэл эхэлсэн тухайд нь мэдээлэх цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээ:	17
ЖИШЭЭ 3: Үзэгдэл зогссон тухайд нь мэдээлэх цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээ: ...	18
ГУРАВДУГААР ХЭСЭГ	19
ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН ТУХАЙ ШУУРХАЙ МЭДЭЭЛЭЛ	19
Х А В С Р А Л Т У У Д	20
А. ҮЗЭГДЭЛ ЭХЭЛСЭН ТУХАЙД НЬ ӨГӨХ МЭДЭЭЛЭЛ	20
Б. ҮЗЭГДЭЛ ЗОГССОН ТУХАЙД НЬ ӨГӨХ МЭДЭЭЛЭЛ	22
ХАВСРАЛТЫН ТАЙЛБАР	23

Эмхтгэн боловсруулсан: Д.Мөнхбат - Увс аймгийн УЦУОШТ-ийн ЗСААХ-ийн дарга,
ЦАЗНЭ-ийн ерөнхий инженер

Хянасан : Г.Амгалан - ЦУОШГ-ын ахлах мэргэжилтэн

Батлуулахаар оруулсан: ЦУОШГ-ын Арга зүйн зөвлөлийн 2023 оны 5 дугаар сарын 23-ны
өдрийн хурлын 1 дүгээр хуралдааны тэмдэглэл

Баталсан: ЦУОШГ-ын даргын 2023 оны ...тоот тушаал

Иш татсан ном хэвлэл, заавар:

- Цаг уур, орчны хяналт шинжилгээний заавар. ШЗ.II.06.04.2008. Ус, цаг агаар, байгаль орчны аюултай үзэгдлийг мэдээлэх заавар. IY дэвтэр (4дэх хэвлэл)
- Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний заавар ШЗ.VIII.03.02. Ус, цаг агаар, байгаль орчны аюултай үзэгдлийн мэдээлэл солилцооны "FM-10-02 АYUUL" код.
- Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлын заавар. ШЗ.VIII.01.2001. Цаг уурын аюултай үзэгдлийн мэдээ солилцооны "FM-10-02 АYUUL" код.
- Ус, цаг агаар, байгаль орчны аюултай үзэгдлийг мэдээлэх заавар IY дэвтэр (3дахь хэвлэл) 1998 он.
- Олон улсын цаг уурын мэдээ солилцооны "FM-12- SYNOP" код
- ДЦУБ-ын кодын заавар 306

Товчилсон үгийн тайлбар

ДЦУБ- Дэлхийн цаг уурын байгууллага

АY – Аюултай үзэгдэл

ОАY-Онц аюултай үзэгдэл

БГY – Байгалийн гамшигт үзэгдэл

УЦУОШТ – Ус цаг уур, орчны шинжилгээний төв

ЦУОШГ – Цаг уур, орчны шинжилгээний газар

УЦУОСМХ – Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн

ОК – Онцгой комисс

БОХЗТЛ–Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори

О Р Ш И Л

Ус, цаг агаар, байгаль орчны аюултай болон онц аюултай үзэгдлийн мэдээ, мэдээлэл нь цаг агаарын байдлыг тасралтгүй хянах, үнэлгээ, дүгнэлт өгөх, учирсан хохирлыг цаг алдалгүй тодорхойлж арга хэмжээ авах, хохирлыг бууруулах чухал ач холбогдолтой.

"FM-10-02 АҮҮҮЛ" код нь ус, цаг агаар, байгаль орчны аюултай үзэгдлийн мэдээлэл солилцоонд хэрэглэгдэнэ.

"FM-10-02 АҮҮҮЛ" кодыг 1998, 2001, 2002, 2008 онуудад шинэчлэн боловсруулах, нэмэлт өөрчлөл оруулах зэргээр хэвлэн гаргасан байдаг.

Сүүлийн жилүүдэд техник, технологийн хурдацтай хөгжил, өөрчлөлтийг даган аюултай үзэгдлийн мэдээг цахимаар дамжуулах болсонтой холбоотой мөн өртөө, харуул дээр ААМО мэдээ зохиохдоо олон тусдаа заавруудыг ашиглах, зарим нэг нь ашиглах боломжгүй болсон, мэдээ дамжуулах программ өөрчлөгдсөн зэрэг нөхцөлүүдийг харгалзан дээрх заавруудыг нэгтгэн боловсруулж, ашиглахад хялбар болгон та бүхэнд хүргэж байна.

ДОТООДЫН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАВ.

Цаг агаарын аюултай болон байгалийн гамшигт үзэгдлийн тухай мэдээний үндсэн ойлголт

Цаг агаарын үзэгдэл, элементийг үнэн зөв урьдчилан мэдээлэхэд аюултай ба гамшигт үзэгдлийн мэдээ маш чухал. "Цаг агаарын аюултай үзэгдэл" гэдгийг өргөн утгаар нь агаар мандалд болж буй физик үзэгдэл, усны үзэгдэл, орчин /агаар, хөрс, ус/-ы ноцтой бохирдол, газар хөдлөл, түймэр, мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын өвчин, хортны хэт олшролт зэрэг байгалийн болон хүний хүчин зүйлийн нөлөөллөөр буй болох нөхцөл гэж ойлгоно. Эдгээр үзэгдлийн эрч хүч нь нэн аюултай үзэгдлийн хэмжээнд хүрч, учруулах хохирлын хэмжээ эрс ихэсвэл "байгалийн гамшигт үзэгдэл" гэж ойлгоно.

Цаг агаарын үзэгдлийг эрч хүч, үргэлжлэх хугацаа, хамрах газар нутгийн хэмжээ, улс нийгэм, аж ахуйн салбар, байгаль орчинд үзүүлэх нөлөөгөөр нь аюултай үзэгдэл /АҮ/, нэн аюултай буюу байгалийн гамшигт үзэгдэл /БГҮ/ гэж ангилна.

Цаг уурын өртөө, харуулд агаар мандлын төлөв байдлыг Ус цаг уурын ажиглалтын заавар /XIV дэвтэр/-ын дагуу тасралтгүй ажиглалт хийж АҮ, БГҮ-ийн эхэлсэн, эрч хүч нь нэмэгдсэн, зогссон, үргэлжилж байгаа тухай болон өртөө, харуул дээр ажиглагдаагүй ч өөрийн аймаг, сумын хаа нэгтэй нь болж өнгөрсөн АҮ, БГҮ-ийн талаар орон нутгийн байгууллага, ард иргэдээс өгсөн мэдээллийг энэхүү зааврын дагуу Төвд шуурхай дамжуулж, улс, аймгийн Онцгой комисс /ОК/-т мэдээлнэ. ОК-оос мэдээлэл авч болно.

Цаг уурын өртөө, харуулын техникч, ажиглагч нар АҮ, БГҮ болоод өнгөрмөгц үзэгдлийн хамарсан газар нутаг, үргэлжилсэн хугацаа, эрч хүч, гарсан хохирлын талаар явуул судалгаа хийн дүрс бичлэг хийх, фото зураг авах, нутгийн иргэдтэй уулзаж ярилцах зэргээр гамшгийн ул мөрийг баримтаар баталгаажуулна. Шаардлагатай гэж үзвэл УЦУОШТ, ЦУОШГ, УЦУОСМХ-гээс мэргэжлийн хүн газар дээр нь очиж холбогдох судалгааг хийнэ.

Гарсан хохирол /алдсан ба хорогдсон малын тоо, төрөл, мөндөрт цохиулсан, цочир хүйтрэлтээр гэмтсэн ургацын хэмжээ, гэмтсэн болон унасан холбоо, цахилгааны тулгуур шон, гэр, хашаа, саравч гэх мэт/-ыг тоон үзүүлэлтээр гаргаж аймгийн УЦУОШТ-д явуулна. Аймгийн УЦУОШТ нь өртөө, харуулаас ирсэн АҮ, БГҮ-ийн тухай мэдээллийг аймгийн байнгын онцгой комисстой хамтран Монгол улсын Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын дагуу яаралтай гаргаж ирүүлнэ.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Ус, цаг агаар, байгаль орчны аюултай үзэгдлийн мэдээлэл солилцооны
"FM-10-02 АYUUL" код

Кодын ерөнхий хэлбэр:

0-ийн хэсэг:

AAMO llll MMDD T_hT_hT_mT_m n

1 дүгээр хэсэг

**111 K'K_zt_wWW 1ddff 2t_vv_v/ 3S_nTT 4h_sh_sg_sg_s (4e_re_re_r/, 4e_me_me_m/, 4hhh/) 5appp
6RRRt_R 7d_hd_h// (7n_Rn_R//, 7UU//) 8t_ht_ht_mt_m (8t_dt_dt_dt_d) 9t_ht_ht_mt_m**

2 дугаар хэсэг

666 K'K_zt_wWW 1zN_sS_aS_a 2S_bS_bS_cS_c 3NNNN

4ddLL 8t_ht_ht_mt_m (8t_dt_dt_dt_d) 9t_ht_ht_mt_m

КОДЫН БҮТЦИЙН ТАЙЛБАР

Код нь дараах үндсэн хэсгээс бүрдэнэ.

Хэсгийн дугаар	Хэсгийн ялгах тоо	Агуулга
0		Кодын нэр, толгойн хэсэг
1	111	Ус, цаг уурын өртөө, харуул дээр ажиглагдсан ус, цаг агаарын аюултай үзэгдлийн тухай аюул, давтан аюул, онц аюул, агаар мэдээний хэсэг
2	666	Ус, цаг уурын өртөө, харуул дээр болон харьяалах нутагт ажиглагдсан байгаль орчны аюултай үзэгдлийн тархалтын тухай аюул, агаар мэдээ болон аюултай үзэгдлээс учирсан хохирлын тухай мэдээллийн хэсэг

Аюултай үзэгдлийн тухай кодолсон мэдээг *Ус, цаг уур, орчны ажиглалтын мэдээ дамжуулах, хяналт тавих систем*-ээр дамжуулна, төгсгөлд нь "=" тэмдгийг заавал бичнэ.

КОДЛОХ ДҮРЭМ

1. Аль нэг үзэгдлийн эрч хүч нь нэмэгдэж АҮ-ийн хэмжээнд хүрвэл "Аюул" мэдээ, цааш үзэгдлийн эрч хүч нэмэгдсэн тухай бүр "Давтан аюул", "Онц аюул" мэдээг, үзэгдэл зогссон буюу эрч хүч нь "АҮ"-ийн хязгаараас буурсан үед "Агаар" мэдээг хавсралтын "А" хэсэгт заасны дагуу зохиож төвд дамжуулна. "Аюул", "Давтан аюул", "Онц аюул" мэдээг уг үзэгдлийн эрч хүч нь заасан хэмжээнд хүрмэгц зохиож, кодлон шууд дамжуулах ба харин "Агаар" мэдээг зохиох нөхцөл бүрдмэгц зохиож 15 минут хүлээгээд дахин уг үзэгдэл "АҮ"-ийн босгыг дээш давахгүй бол төвд дамжуулна. Харин уг үзэгдэл "БГҮ"-ийн хэмжээнд хүрээд эрч хүч нь буурсан ч гэсэн "АҮ"-ийн хязгаараас доош орохгүй бол тусгайлан "Агаар" мэдээ зохиохгүй.

Кодын нэг хэсэгт нэг аюул, эсвэл нэг агаар мэдээг өгнө. Өөрөөр хэлбэл: Аюул, Агаар мэдээ тус бүр нэг, нэг хэсэг болно.

2. Кодын тэгийн хэсэг буюу AAMO IIIii MMDD T_hT_hT_mT_mn бүлгүүдийг мэдээнд заавал өгнө.

3. Кодын хэсгийн өмнөх ялгах тоо 111, 666 байна.

4. Кодын хэсэгт K^l K_z t_w WW бүлгийг заавал өгнө.

5. Хэрэв тухайн бүлэгт өгөгддөг үзүүлэлтүүдийг тодорхойлоогүй бол тухайн бүлгийг орхиж кодолно. Өрөөр хэлбэл; хүчтэй салхины "Аюул" мэдээнд зөвхөн 1ddff бүлгийг өгөх ба бусад бүлгийг орхиж кодолно.

6. Ус, цаг агаарын аюултай үзэгдэл болон ургамлын өвчин, хортон, мал амьтны халдварт өвчний дараах "Агаар" мэдээнд аюултай үзэгдлийн үргэлжилсэн хугацааг заавал өгнө.

7. "Онц аюул" мэдээ өгсөн бол Онц аюултай үзэгдлийн үргэлжилсэн хугацааг 9t_ht_ht_mt_m бүлгээр заавал өгнө. Тухайлбал: Хүчтэй салхины хувьд "Аюул" үргэлжилсэн хугацаанд 15м/с-ээс их, харин "Онц аюул" үргэлжилсэн хугацаанд 28м/с ба түүнээс их хурдтай байсан хугацааг ялгаж өгнө.

8. Бүх аюултай үзэгдлээс хохирол учирсан тохиолдолд хохирлын мэдээг "Ус, цаг уур, орчны ажиглалтын мэдээ дамжуулах систем"-ийн 2-р хэсгийн "талбар" хэсэгт текст хэлбэрээр өгнө.

**“FM-10-02 АҮҮЛ” КОДЫН ТОМЬЁОЛСОН ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ НЭР,
ХЭРЭГЛЭХ ТАЙЛБАР**

Бүлэг	Тэмдэг-лэгээ	Тайлбар
1	2	3
AAMO	AAMO	АҮ-ийн мэдээлэл болохыг таних кодын толгойн хэсэг. Аюул, Агаар, Монгол гэсэн үгийн товчлол.
IIII	IIII	Ус, цаг уурын өртөө, харуулын индекс. Мэдээ болгонд заавал өгнө.
MMDD	MM	АҮ-ийн эхэлсэн /зогссон/ сарын дугаар. Нэгдүгээр сар бол 01, Арваннэгдүгээр сар бол 11 г.м. 2 оронгоор кодолно.
	DD	АҮ-ийн эхэлсэн /зогссон/ өдөр. Нэгний өдрийг 01, Арваннэгний өдрийг 11 г.м. 2 оронгоор кодолно.
T _h T _h T _m T _m n	T _h T _h	АҮ-ийн эхэлсэн /зогссон/ цаг. Цагийг 2 оронгоор Улаанбаатарын өвлийн улирлын цагаар өгнө.
	T _m T _m	АҮ-ийн эхэлсэн /зогссон/ минут. Минутыг 2 оронгоор кодолно. 8 минутанд үзэгдэл эхэлсэн/зогссон бол 08 гэж кодолно.
	n	тогтмол “1” байна
K'K _z t _w WW	K'	АҮ-ийн тухай мэдээний төрөл. 1 дүгээр хүснэгтийн дагуу кодолно.
	K _z	Тухайн АҮ-ээс хохирол учирсан эсэх. 1 дүгээр хүснэгтийн дагуу кодолно.
	t _w	АҮ-ийн үргэлжилсэн хугацааг кодонд өгсөн эсэх. 2 дугаар хүснэгтийн дагуу кодолно.
	WW	АҮ-ийн нэр. Ус, цаг агаарын гамшигт үзэгдэл ажиглагдсан бол 3 дугаар хүснэгт; байгаль орчин, ургамлын өвчин, хортон, малын халдварт өвчин бол 4 дүгээр хүснэгтийн дагуу кодолно.
1ddff	1	Бүлгийн ялгах тоо
	dd	Салхины чиглэл. АК-01 кодын адил кодолно.
	ff	Салхины хурд. АК-01 кодын адил кодолно.
2t _v VV/	2	Бүлгийн ялгах тоо
	t _v	Алсын бараа тодорхойлсон арга. Алсын барааг нүдэн баримжаагаар тодорхойлсон бол 1, автомат хэмжигчээр тодорхойлсон бол 2 гэж кодолно.
	VV	Алсын барааны харагдац. АК-01 кодын адил кодолно. Алсын барааг тодорхойлох боломжгүй байсан (шөнийн хугацаанд г.м.) бол 2//// гэж кодолно.
	/	Орон гүйцээх ташуу тэмдэгт
3S _n TTT	3	Бүлгийн ялгах тоо
	S _n	Агаарын температурын тэмдэг. АК-01 кодын адилаар “+” бол 0, “-” бол 1
	TTT	Агаарын температур. АК-01 кодын адил. Аравны нарийвчлалтайгаар кодолно.
4h _s h _s g _s g _s	4	Бүлгийн ялгах тоо
	h _s h _s	Цасан бүрхүүлийн зузаан. 5 дугаар хүснэгтийн дагуу 2 оронгоор, бүхлээр кодолно.
	g _s g _s	Цасны нягт. 5 дугаар хүснэгтийн дагуу зууны нарийвчлалтай утгын сүүлийн 2 оронгоор кодолно. Жишээ нь: нягт 0,01 г/см ³ бол 01, 0,20 г/см ³ бол 20 г.м.
4e _r e _r e _r /	4	Бүлгийн ялгах тоо
	e _r e _r e _r	Цанталтын зузаан. 5 дугаар хүснэгтийн дагуу 3 оронгоор кодолно. Жишээ нь 1мм зузаантай цан үүссэн бол 001 г.м.
	/	Орон гүйцээх ташуу тэмдэгт
4e _m e _m e _m /	4	Бүлгийн ялгах тоо
	e _m e _m e _m	Мөстлөгийн зузаан. 5 дугаар хүснэгтийн дагуу 3 оронгоор кодолно. Жишээ нь: 1мм зузаантай мөстөлт үүссэн бол 001 г.м.
	/	Орон гүйцээх ташуу тэмдэгт
4hhh/	4	Бүлгийн ялгах тоо
	hhh	Голын усны түвшин. Хэрэв усны түвшний хэмжилт хийдэг бол кодонд 3 оронгоор өгнө. Хийдэггүй бол өгөхгүй. Жишээ нь: Голын усны түвшин 188 см бол 188 г.м.
	/	Орон гүйцээх ташуу тэмдэгт

1	2	3
5appp	5	Бүлгийн ялгах тоо
	a	Агаарын даралтын өөрчлөлтийн шинж. АК-01 кодын адил кодолно.
	ppp	Агаарын даралтын өөрчлөлтийн хэмжээ. АК-01 кодын адил аравны нарийвчлалтайгаар 3 оронгоор кодолно. Жишээ нь: 7.3 гПа-аар даралт өөрчлөгдсөн бол 073 г.м.
6RRRt _R	6	Бүлгийн ялгах тоо
	RRR	Хур тунадасны хэмжээ. АК-01 кодын адил аравны нарийвчлалтайгаар 3 оронгоор кодолно.
	t _R	Хур тунадсыг хэмжсэн хугацаа. 2 дугаар хүснэгтийн дагуу кодолно.
7d _h d _h //	7	Бүлгийн ялгах тоо
	d _h d _h	Мөндрийн голч. АК-01 кодын дагуу 2 оронгоор кодолно.
	//	Орон гүйцээх ташуу тэмдэгт
7n _R n _R //	7	Бүлгийн ялгах тоо
	n _R n _R	Хур тунадасны өнгө. Өнгөт тунадас орсон тохиолдолд өгөх ба 6 дугаар хүснэгтийн дагуу кодолно. Жишээ нь: Ягаан өнгөтэй бол 1 г.м.
	//	Орон гүйцээх ташуу тэмдэгт
7UU//	7	Бүлгийн ялгах тоо.
	UU	Агаарын харьцангуй чийг. Агаарын харьцангуй чийг 30% ба түүнээс бага болж халуун, хуурай салхи ажиглагдах үед бүхэл, 2 оронгоор 6 дүгээр хүснэгтийн дагуу кодолно.
	//	Орон гүйцээх ташуу тэмдэгт
8t _h t _h t _m t _m	8	Бүлгийн ялгах тоо.
	t _h t _h	АҮ-ийн үргэлжилсэн хугацаа, цагаар. АҮ-ийн үргэлжилсэн хугацааг 2 оронгоор, бүхлээр "агаар" мэдээнд заавал өгнө. Жишээ нь: АҮ нэг цаг үргэлжилсэн бол 01, 11 цаг үргэлжилсэн бол 11 г.м.
	t _m t _m	АҮ-ийн үргэлжилсэн хугацаа, минутаар. 2 оронгоор, бүхлээр кодолно. Жишээ нь: 15 минут үргэлжилсэн бол 15 г.м.
8t _d t _d t _d t _d	8	Бүлгийн ялгах тоо.
	t _d t _d t _d t _d	АҮ-ийн үргэлжилсэн хугацаа, өдрөөр. Байгаль орчны болон ургамлын өвчин, хортон, мал, амьтадын халдварт өвчний үед АҮ үргэлжилсэн өдрийг 4 оронгоор кодолно.
9t _h t _h t _m t _m	9	Бүлгийн ялгах тоо.
	t _h t _h	ОАҮ-ийн үргэлжилсэн хугацаа, цагаар. "Онц аюул" мэдээ өгсөн бол уг үзэгдэл зогсоход ОАҮ-ийн үргэлжилсэн хугацааг бүхэл 2 оронгоор заавал өгнө.
	t _m t _m	ОАҮ-ийн үргэлжилсэн хугацаа, минутаар. 2 оронгоор бүхлээр кодолно. Жишээ нь: 15 минут бол үргэлжилсэн бол 15, 30 минут үргэлжилсэн бол 30 г.м.
1zN _s S _a S _a	1	Бүлгийн ялгах тоо.
	z	NNNN-д ямар үзүүлэлт өгснийг заана. 7 дугаар хүснэгтийн дагуу халдвар авсан хүний тоог өгч байгаа бол 0, бэлчээрийн талбайн хэмжээг га-гаар өгч байгаа бол 5, хорогдсон малын тоог өгч байгаа бол 7, хохирлын дүнг төгрөгөөр өгч байгаа бол 8 г.м. кодолно.
	N _s	АҮ хамарсан талбайн хэмжээ, хохирлын дүнгийн нарийвчлал. АҮ хамарсан талбайн хэмжээ, хохирлын дүнгийн нарийвчлалыг кодлохдоо 8 дугаар хүснэгтийг ашиглах ба нэгжийн оронгоор бүхэлтгэсэн бол 1, зуутын оронгоор бүхэлтгэсэн бол 2 г.м. кодолно.
	S _a S _a	АҮ хамарсан сумын тоо. Аянга буусан, голын, уруйн, шар усны үер, уулын цас, мөсний нуралт болсон, гол, нуурын мөс цөмөрсөн, газар хөдөлсөн, ой, хээрийн түймэр, халдварт өвчин гарсан, хортон тархсан тохиолдолд өгнө. Сумын тоог 2 оронгоор бүхлээр кодолно. Жишээ нь: 1 сумыг хамарсан бол 01, 10 сумыг хамарсан бол 10 г.м.
2S _b S _b S _c S _c	2	Бүлгийн ялгах тоо.
	S _b S _b	АҮ хамарсан багийн тоо. S _a S _a -г өгсөн тохиолдолд S _b S _b заавал өгнө. Багийн тоог 2 оронгоор бүхлээр кодолно. Жишээ нь: 1 багийг хамарсан бол 01, 10 багийг хамарсан бол 10 г.м.
	S _c S _c	АҮ хамарсан хот айл, суурь аж ахуйн нэгжийн тоо. S _a S _a -г өгсөн тохиолдолд S _c S _c заавал өгнө. Хот айл, суурь, аж ахуйн нэгжийн тоог 2 оронгоор бүхлээр кодолно. Жишээ нь: 2 хот айлыг хамарсан бол 02, 3 суурийг бол 03 г.м.

1	2	3
3NNNN	3	Бүлгийн ялгах тоо.
	NNNN	Хамарсан талбай, хохирлын хэмжээ. 8 дугаар хүснэгтийн дагуу кодолно. Жишээ нь: 120 га талбайд бэлчээрийн хортон тархсан бол 0120 гэж кодлох ба энэ тохиолдолд z –ийг 5, N _s –ийг 0 г.м. нэгжийн оронгоор өгсөн гэж кодолно.
4ddLL	4	Бүлгийн ялгах тоо.
	dd	Өртөө, харуулаас өөр газар болсон АҮ-ийн зүг чиг. Өртөө, харуулаас аль зүгт АҮ болсныг АК-01 кодонд салхины чиглэлийг кодолдогийн адилаар 4 зүг, 8 зовхисоор 2 оронгоор кодолно. Жишээ нь: БХ зүгт АҮ болсон бол 32, Б зүгт болсон бол 27, ЗӨ зүгт болсон бол 14 г.м.
	LL	Өртөө, харуулаас өөр газар болсон АҮ-ийн алслалт /хэдэн км зайд болсон/. Өртөө, харуулаас хэдэн км зайд АҮ болсныг 6 дугаар хүснэгтийн дагуу 2 оронгоор кодолно. Жишээ нь: АҮ өртөө, харуулаас 5км-ээс бага зайд болсон бол 00, 10 км орчимд болсон бол 01, 200 км орчим алслагдсан газар болсон бол 20 г.м.

1 дүгээр хүснэгт

Мэдээний төрөл K ₁	Кодын тоо	Хохирол гарсан эсэх K ₂	Кодын тоо
Агаар	0	Хохирол гараагүй	0
Аюул	1	Хохирол гарсан, мэдээнд өгөөгүй	1
Давтан аюул	2	Хохирол гарсан, 2-р хэсэгт өгсөн	2
Онц аюул	3	Хохирлыг 2-р хэсэг болон текстээр өгсөн	3
		Хохирол гарсан эсэх тодорхойгүй	4

2 дугаар хүснэгт

АҮ-ийн үргэлжилсэн хугацааг өгсөн эсэх t _w	Кодын Тоо	Тунадсыг хэмжсэн хугацаа, t _R	Кодын тоо
АҮ-ийн үргэлжилсэн хугацаа өгөөгүй	0	1 цагт	1
АҮ-ийн үргэлжилсэн хугацааг цаг, минутаар өгсөн	1	12 цагт	2
АҮ-ийн үргэлжилсэн хугацааг хоногоор өгсөн	2	3 цагт	3

3 дугаар хүснэгт

АҮ-ийн төрөл	Аюултай үзэгдлийн нэр	Кодын тоо	Кодын аль хэсэгт	Кодонд тусгах үндсэн болон дагалдах үзүүлэлтүүдийг өгөх хэлбэр				
Цаг агаарын үзэгдэл	Хүчтэй салхи	01	1	1ddff	8tntntmtm	-	-	
	Цасан шуурга	02	1	1ddff	2tvVV/	8tntntmtm	-	
	Шороон шуурга	03	1	1ddff	2tvVV/	8tntntmtm	-	
	Орон шуурга	04	1	1ddff	2tvVV/	8tntntmtm	-	
	Цас	05	1	2tvVV/	8tntntmtm	-	-	
	Бороо	06	1	2tvVV/	8tntntmtm	-	-	
	Нойтон цас	07	1	3S _n TTT	8tntntmtm	-	-	
	Цанталт	08	1	3S _n TTT	4e.e.e.r/	8tntntmtm	-	
	Мөстөлт	09	1	3S _n TTT	4e.m.e.m/	8tntntmtm	-	
	Даралтын бууралт	10	1	5appp				
	Зузаан цас	11	1	4hshsgsgs	8tntntmtm			
	Мөндөр	12	1	7dhdh//	3S _n TTT			
	Нөөлөг салхи**	13	1	1ddff				
	Өнгөт тунадас	14	1	6RRRt _R	7hrhr//	8tntntmtm		
	Хүйтэн бороо	15	1	1ddff	3S _n TTT	8tntntmtm		
	Халуун, хуурай салхи	16	1	7UU//	8tntntmtm			
	Ширүүн аадар бороо	17	1	6RRRt _R	8tntntmtm			
	Догшин хуй салхи /торнадо/**	18	1-2	1ddff	4ddLL	8tntntmtm	8tntntmtm	
	Аянга цахилгаан	19	2	4ddLL	8tntntmtm			
Үер, усны мэдээ	Голын үер	20	1-2	4hhh/	4ddLL	8tntntmtm		
	Уруйн үер	21	1-2	6RRRt _R	4ddLL	8tntntmtm		
	Шар усны үер	22	2	1zN _s S _s S _s	2S _b S _b S _c S _c	3NNNN	4ddLL	8tntntmtm
	Гол, нуурын мөс цөмрөлт	23	2	1zN _s S _s S _s	2S _b S _b S _c S _c	3NNNN	4ddLL	8tntntmtm
Түймрийн мэдээ	Ойн түймэр	24	2	1zN _s S _s S _s	2S _b S _b S _c S _c	3NNNN	4ddLL	8tntntmtm
	Хээрийн түймэр	25	2	1zN _s S _s S _s	2S _b S _b S _c S _c	3NNNN	4ddLL	8tntntmtm
	Ой хээрийн хавсарсан түймэр	26	2	1zN _s S _s S _s	2S _b S _b S _c S _c	3NNNN	4ddLL	8tntntmtm
Бусад	Өртөө, харуул дээр газар хөдөлсөн	27	2	1zN _s S _s S _s	2S _b S _b S _c S _c	3NNNN	4ddLL	8tntntmtm
	Өртөө, харуул дээр мэдрэгдээгүй	28	2	1zN _s S _s S _s	2S _b S _b S _c S _c	3NNNN	4ddLL	8tntntmtm
	Уулын цас мөсний нуралт	29	2	1zN _s S _s S _s	2S _b S _b S _c S _c	3NNNN	4ddLL	8tntntmtm

Тайлбар: * Зөвхөн хохирол гарсан тохиолдолд мэдээлнэ.

** Хуйларсан хөдөлгөөнтэй, С_b үүлтэй холбоотой үүсдэг салхи.

ЖИЧ: Онц аюултай үргэлжилсэн хугацааг аюултай үргэлжилсэн хугацаанаас ялгаж 9tntntmtm бүлгээр мэдээлнэ.

АУ-ийн төрөл	Аюултай үзэгдлийн нэр	WW Кодын тоо	Кодын аль хэсэгт өгөх	Кодонд тусгах үндсэн болон дагалдах үзүүлэлтүүдийг өгөх хэлбэр				
Мал, амьтны гоц халдварт өвчнүүд	Тарваган тахал	30	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Шүлхий	31	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Мялзан үхэр гахай	32	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Цэцэг хонь ямааны	33	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Бусад тахал	34	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Боом	35	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Галзуу	36	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Томуу, халдварт ханиад	37	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Годрон	38	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Цусан халдвар	39	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Дуут	40	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Ям	41	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Сахуу	42	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Сохор догол	43	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Хордлого, халдварт хордлого	44	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Бусад	45	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	 Г.М.	49	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Үлийн цагаан огтоно	50	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
Ургамлын өвчин, хортон	Царцаа, дэвхрэг	51	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Голио	52	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Эрвээхэй /нугын бор, өрөөсгөл хүр/	53	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Хивэн /байцааны, чацарганы, наранцэцгийн../	54	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Бүгэг /байцааны.../	55	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Ялаа /Гессений, шведийн, хөндийлөгч/	56	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Хүлэмжийн цагаан далавчтан	57	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Хачиг /энгийн, шүлхий, үндэсний../	58	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Өрөөсгөл хатгуурт хүр хорхой	59	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Цох /үсрэгч, судалт, колорадын, шөвгөр.../	60	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Бөөс /алимны, манжингийн, байцааны.../	61	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Бясаа /манжингийн.../	62	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Манжингийн шөвгөлж	63	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Манжингийн хугалж	64	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Харуу /тоосон, хатуу, ишний/	65	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Зэв	66	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Гуалах өвчин /хуурмаг гуалах/	67	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Түрүүний фузариоз	68	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Төмсний фитифрот	69	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Хар хөлхөн /төмс/	70	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Цагирган ялзрал /төмс/	71	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Бусад хортон	72	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Бусад өвчин	73	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Танихгүй хортон	74	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata
	Танихгүй өвчин	75	2	1zNsSsSs	2SbSbScSc	3NNNN	4ddLL	8tataata

5 дугаар хүснэгт

Цасан бүрхүүлийн зузаан		Цасны нягт		Цанталт, мөстөлтийн зузаан	
Зузаан (см)	Кодын тоо	Нягт (г/см ³)	Кодын тоо	Зузаан (мм)	Кодын тоо
20	20	0,01	01	1	001
21	21	0,02	02	2	002
22	22	...	...	3	003
23	23	0,10	10	4	004
...	...	0,11	11	5	005
80	80	0,12	12	6	006
81-90	81	...	...	7	007
91-100	82	0,20	20	8	008
101-110	83	0,21	21	9	009
...	...	...	...	10	010
231-240	96	0,30	30	11	011
241-250	97	0,31	31	12	012
251-260	98	...	...	...	...
260≤	99	...0.01г/см ³ -ээр нэмэгдэнэ		...1 мм-ээр нэмэгдэнэ	

6 дугаар хүснэгт

Хур тунадасны өнгө		АҮ гарсан газрын алслалт		Агаарын харьцангуй чийг	
Өнгө	Кодын тоо	Алслалт (км)	Кодын тоо	Утга (%)	Кодын тоо
Ягаан	01	>5	00	30	30
Хөх	02	5-10	01	29	29
Цэнхэр	03	11-20	02	28	28
Ногоон	04	21-30	03	27	27
Шар ногоон	05	...	...	26	26
Шар	06	81-90	09	25	25
Улбар шар	07	91-100	10	24	24
Улаан	08	101-110	11	23	23
Бор	09	...	...	22	22
Хүрэн	10	941-950	95	21	21
Цагаан	11	951-960	96	20	20
Хар	12	961-970	97	19	19
Саарал	13	971-980	98	18	18
		980≤	99	...1%-иар буурна	

7 дугаар хүснэгт

Z-ийн утга	Кодын тоо
Халдвар авсан, нэрвэгдсэн хүний тоо	0
Халдвар авсан малын тоо	1
Халдвар авсан амьтны тоо	2
Жимсний мод, бутны тоо	3
Тариалангийн талбай га-гаар	4
Бэлчээрийн талбай, га-гаар	5
Ойн талбай, га-гаар	6
Хорогдсон мал, амьтны тоо	7
Гарсан хохирлын дүн, төгрөгөөр	8
Осолдсон хүний тоо	9

8 дугаар хүснэгт

Ns -ийн утга	Кодын тоо	NNNN –ийн утга	Кодын тоо
Нэгжийн оронгоор	0	1234	1234
Бүхэл аравтын оронгоор	1	12340	1234
Бүхэл зуутын оронгоор	2	123400	1234
Бүхэл мянгатын оронгоор	3	1234000	1234
...	...	...	...
Бүхэл саятын оронгоор	6	1234000000	1234

ХОЁРДУГААР ХЭСЭГ

УС, ЦАГ АГААР, БАЙГАЛЬ ОРЧНЫ АЮУЛТАЙ ҮЗЭГДЛИЙГ МЭДЭЭЛЭХ ЗААВАР

2.1. Аадар бороо орсон буюу хавар цас эрчимтэй хайлсны улмаас "Уруйн" үер буух, газар хөдлөх, мөнх цаст уулын цас, мөсний тасралт, нуралт үүсэх, өнгөт хур тунадас, элдэв зүйлээр бороо орсон (шороотой, цастай г.м.), догшин хуй салхи, туйлын туяа, хортон шавьж эрс олшрох, ахуйн болон үйлдвэрийн бохирдлоор гадаргын болон гүний ус хүчтэй бохирдсон, ан амьтан, ургамал үхэж хорогдсон, тухайн нутагт шинээр буй болсон буюу хэт үржсэн, таримал болон бэлчээрийн ургамал ихээр гэмтсэн, цаг бусын үзэгдэл (зун цас орох, өвөл бороо орох, хавар эрт, намар орой тэнгэр дуугарах г.м.) ажиглагдсан тухай мэдээллийг Аюул мэдээ, авсан эх сурвалжийг заан "бичвэр" хэлбэрээр өгнө.

2.3. Холбоо, сүлжээний саатал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар "АҮ", "БГҮ"-ийн тухай мэдээг хугацаанд нь дамжуулж чадаагүй бол /үзэгдэл зогссоны дараа ч гэсэн/ холбоо, сүлжээ ажилд ормогц "Аюул", "Агаар" мэдээг заавал нөхөн өгнө.

2.4. АҮ, БГҮ эхэлсэн, эрч хүч нь нэмэгдсэн, зогссон тухай "ААМО" мэдээг ажиглалтын мэдээ дамжуулах хугацааг харгалзахгүйгээр өгнө.

2.5. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өмч хөрөнгө, байгаль орчинд ихээхэн хохирол учруулсан цаг агаарын аюултай, байгалийн гамшигт үзэгдлийг зөвхөн өртөө, харуулын орчимд бус өөрийн аймаг, сумын нутгийн хаа нэгтэй болсон тохиолдол бүрт энэ тухай тодорхой мэдээг эрэн сурвалжилж яаралтай ирүүлнэ.

2.6. АҮ, БГҮ-ийн мэдээнд дараах мэдээлэл тогтмол тусгагдах ба аль болох ойлгомжтой, товчхон, тодорхой байна. Үүнд:

- Мэдээний толгой, огноо: IIIII MMDD T_nT_hT_mT_{mn} кодоор
- Таних үг "Аюул", "Давтан аюул", "Онц аюул", "Агаар" мэдээг кодын зааврын 1 дүгээр хүснэгтийн дагуу 1, 2, 3, 0 гэж өгнө.
- Үзэгдэл эхэлсэн буюу эрч хүч нь нэмэгдсэн, үргэлжилсэн хугацаа. /Улаанбаатарын хуулийн /өвлийн/ цаг, минутаар/.
- Үзэгдлийн нэр, түүний эрч хүч.
- Үзэгдлийг нөхцөлдүүлж буй цаг уурын бусад элементийн утга /хавсралтын дагуу заавал тусгах зүйлд заасан элемент/.
- Мэдээ өгч буй өртөө, харуулын дугаар, мөн түүнчлэн хавсралт "А"-д заасан үзэгдэл эхэлсэн, эрч хүч нь нэмэгдсэн, тухай бүр "Аюул", "Давтан аюул", "Онц аюул" мэдээг өгч, үзэгдэл зогссон тухай "Агаар" мэдээг заавал өгнө. Харин хавсралт "Б"-д заасан үзэгдэл ажиглагдаад зогсмогц зөвхөн "Аюул" мэдээг зохиож өгнө.

2.7. Үзэгдэл эхэлсэн, эрч хүч нь нэмэгдсэн ба үргэлжилсэн хугацааг дөрвөн оронгоор өгнө.

- Үзэгдлийн эхэлсэн хугацаа гэдэг нь: Уг үзэгдлийн эрч хүчний хэмжээ АҮ, БГҮ-ийн босгыг давсан хугацаа /цаг, минут/-г хэлнэ.
- Цаг агаарын АҮ, БГҮ-ийн үргэлжилсэн хугацаа гэдэг нь: үзэгдлийн эхэлсэн ба зогссон АҮ, БГҮ-ийн хязгаараас доош орсон хугацаа /цаг, минут/-ны хоорондын ялгавар юм.
- Хүчтэй салхины хувьд "аюултай" үргэлжилсэн хугацаанд 15 м/с ба түүнээс их, "онц аюултай" үргэлжилсэн хугацаанд 28 м/с ба түүнээс их хурдтай байсан хугацааг авна.

2.8. Салхи шуурганы ААМО мэдээнд флюгерийн 2 минутын дундаж, автомат станцын 10 минутын дундаж зүг, хурдыг өгнө.

ЖИШЭЭ 1: Үзэгдэл эхэлсэн тухайд нь мэдээлэх цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээ:

Увс аймгийн Малчин (44201) өртөөнд 2 дугаар сарын 12-ны 05 цаг 30 минутад цас орж, орон шуурга шуурч эхлэв. Энэ үед алсын барааны харагдац 4км, салхи баруун өмнөөс 7м/с байснаа 07 цагт салхи баруунаас 12м/с болж, хараа 2000м-ээс муудав. 13 цаг 25 минутад цас зогсож, салхи баруун хойноос 16м/с болж, цасан шуурга шуурчээ. Энэ үед алсын барааны харагдац 1000м байв. 13 цаг 40 минутад салхи баруун хойноос 18м/с хүрэхэд алсын барааны харагдац 500м болж буурснаа 17 цагт салхи баруун хойноос 12м/с болж цасан шуурга намдаж алсын барааны харагдац 2000м-ээс их болов. 18 цаг 15 минутад салхи хойноос 9м/с болсон байна. Ямар нэг хохирол гараагүй.

- 05 цаг 30 минутад орон шуургаар мэдээ өгнө. Нэг үзэгдлийн тухай мэдээ өгөх учраас $n=1$, үргэлжилсэн хугацаа өгөхгүй тул $t_w=0$, $dd=23$, $ff=07$, алсын барааг нүдэн баримжаагаар тодорхойлсон бол $t_v=1$, $VV=96$ байна.
 - Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_{mn}$ 111 K'K_{ztw}WW 1ddff 2 t_v VV/
 - Кодолсон нь: AAMO 44201 0212 05301 111 14004 12307 2196/=
- 07 цагт алсын барааны харагдац 2000м-ээс муудсан тул орон шуурганы "Давтан аюул" мэдээ өгнө. Нэг мэдээ өгөх учраас $n=1$, үргэлжилсэн хугацаа өгөхгүй тул $t_w=0$ байна.
 - Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_{mn}$ 111 K'K_{ztw}WW 1ddff 2 t_v VV/
 - Кодолсон нь: AAMO 44201 0212 07001 111 24004 12712 2194/=
- 13 цаг 25 минутад цас тогтсон тул орон шуурганы "Агаар" мэдээ өгөх ба салхи 15м/с хүрсэн тул хүчтэй салхины "Аюул" өгнө. Мөн алсын барааны харагдац 1000м хэвээр байгаа тул цасан шуурганы "Аюул" мэдээ өгнө. /Энэ жишээнд 3 төрлийн мэдээ зохиож өгөхөөр байна/, Тус тусд нь зохиож өгөх учраас $n=1$, Орон шуурганы "Агаар" мэдээнд $t_w=1$ байх ба үргэлжилсэн хугацаа 13:25 – 05:30 = 07цаг 55 минут байна.
 - Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_{mn}$ 111 K'K_{ztw}WW 1ddff 2 t_v VV/ 8 $t_h t_h t_m t_m$
 - Кодолсон нь: AAMO 44201 0212 13251 111 04104 13215 2194/ 80755=
 - Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_{mn}$ 111 K'K_{ztw}WW 1ddff
 - Кодолсон нь: AAMO 44201 0212 13251 111 14001 13215=
 - Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_{mn}$ 111 K'K_{ztw}WW 1ddff 2 t_v VV/ =
 - Кодолсон нь: AAMO 44201 0212 13251 111 14002 13215 2194/=
- 13 цаг 40 минутад алсын барааны харагдац 500 м-ээс бага болж муудсан тул цасан шуурганы "Давтан аюул" мэдээ өгнө. Нэг мэдээ өгөх учраас $n=1$, үргэлжилсэн хугацаа өгөхгүй тул $t_w=0$ байна.
 - Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_{mn}$ 111 K'K_{ztw}WW 1ddff 2 t_v VV/
 - Кодолсон нь: AAMO 44201 0212 13401 111 24004 13218 2192/=
- 17 цаг 00 минутад алсын барааны харагдац 2км-ээс их болж цасан шуурга намдсан тул цасан шуурганы "Агаар" мэдээ өгнө. Нэг мэдээ өгөх тул $n=1$, цасан шуурганы үргэлжилсэн хугацаа /17:00–13:25= 03 цаг 35 минут/ өгөх тул $t_w=1$ байна.
 - Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_{mn}$ 111 K'K_{ztw}WW 2 t_v VV/ 8 $t_h t_h t_m t_m$
 - Кодолсон нь: AAMO 44201 0212 17001 111 00104 1196/ 80335=
- 18 цаг 15 минутад салхины хурд 10 м/с-ээс бага болж 9м/с болсон тул салхиар "Агаар" мэдээ өгнө. Нэг хэсэг мэдээ өгөх тул $n=1$, хүчтэй салхины үргэлжилсэн хугацаа /14.10 –13.25 = 45 минут/ ба $t_w=1$ байна.
 - Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_{mn}$ 111 K'K_{ztw}WW 1ddff 8 $t_h t_h t_m t_m$
 - Кодолсон нь: 44201 0212 18151 111 00101 13609 80045=

ЖИШЭЭ 2: Үзэгдэл эхэлсэн тухайд нь мэдээлэх цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээ:

Увс аймгийн Завхан өртөөнд (44216) 8 дугаар сарын 15-17-нд 14 цагийн харьцангуй чийг 30, 26, 24% болж, хуурайшил ажиглагдав. Хуурайшил 18-20-нд үргэлжлэн ажиглагдсан ба энэ өдрүүдэд 14 цагийн харьцангуй чийг 25, 16, 22% байв. 8 дугаар сарын 21-нд 14 цагийн харьцангуй чийг 32% болсон хэдий ч 8 дугаар сарын 22, 23-нд 28, 19% байсан байна. Харин 8 дугаар сарын 24-ний 06 цаг 35 минутаас бороо орж, 24-ний 14 цагт чийг 78%, 25-ны 14 цагт 45% байжээ.

- 8 дугаар сарын 17-нд хуурайшлаар "Аюул" мэдээ өгөх ба $(30+26+24):3=27\%$ -ийг кодолно. Нэг мэдээ өгөх тул $n=1$, үргэлжилсэн хугацааг хоногоор өгөх тул $t_w=2$ байна.
 - Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_{mn}$ 111 K'K_{ztw}WW 7UU// 8 $t_h t_h t_m t_m$
 - Кодолсон нь: AAMO 44216 0815 14001 111 14216 727// 80003=
- 8 дугаар сарын 20-нд хуурайшлаар "Давтан аюул" мэдээ өгөх ба $(25+16+22):3=21\%$ -ийг кодолно. Нэг мэдээ өгөх тул $n=1$, үргэлжилсэн хугацааг хоногоор өгөх тул $t_w=2$ байна.
 - Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_{mn}$ 111 K'K_{ztw}WW 7UU// 8 $t_a t_a t_a t_a$
 - Кодолсон нь: AAMO 44216 0820 14001 111 24216 721// 80006=
- 8 дугаар сарын 23-нд хуурайшлаар дахин "Давтан аюул" мэдээ өгөх ба $(32+28+19):3=26\%$ -ийг кодолно. Нэг мэдээ өгөх тул $n=1$, үргэлжилсэн хугацааг хоногоор өгөх тул $t_w=2$ байна.
 - Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_{mn}$ 111 K'K_{ztw}WW 7UU// 8 $t_a t_a t_a t_a$
 - Кодолсон нь: AAMO 44216 0823 14001 111 24216 726// 80009=
- 8 дугаар сарын 25-ны 14 цагийн ажиглалтын дараа "Хуурайшлаар" "Агаар" мэдээ өгөх ба $(78+45):2=62\%$ -ийг кодолно. Нэг мэдээ өгөх тул $n=1$, үргэлжилсэн хугацааг хоногоор өгөх тул $t_w=2$ байна.
 - Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_{mn}$ 111 K'K_{ztw}WW 7UU// 8 $t_a t_a t_a t_a$
 - Кодолсон нь: AAMO 44216 0825 14001 111 04216 762// 80009=

ЖИШЭЭ 3: Үзэгдэл зогссон тухайд нь мэдээлэх цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээ:

Увс аймгийн Наранбулаг (44199) өртөөнөөс зүүн хойт зүгт 25км зайтай газарт 7 дугаар сарын 01-ний 19 цагийн орчим ширүүн аадар бороо орж, уруйн үер буусны улмаас 1 багийн 2 хот айлын 45 мал хорогдсон ба нийт 6 293 000 төг-ийн хохирол учирсан. Ширүүн аадар бороо 3 цаг орчим үргэлжилсэн гэсэн мэдээлэл иржээ.

- Уруйн үер /ww=21/-ээр "Аюул" мэдээ өгнө. Өртөөнөөс хол ажиглагдсан тул 6RRRtR бүлгийг өгөх бололцоогүй. n=1, SaSa=01, SbSb=01, ScSc=02, зүг dd=05, алслалт LL=03, үргэлжилсэн хугацааг цаг, минутаар өгөх тул $t_w=1$ байна. Хохирол хорогдсон мал 45 /z=7, Ns=0, NNNN=0045/, мөнгөн дүн 6293000 төг /z=8, Ns=3, NNNN=6293/-г тус тусад нь мэдээлнэ. т.е: Энэ тохиолдолд малын тоо ба мөнгөн дүнг $1zN_sS_aS_a$ 3NNNN бүлгээр тусад нь давтан өгнө,
 - Код: AAMO llll MMDD T_hT_hT_mT_mn 666 K'K_zt_wWW 1zN_sS_aS_a 2S_bS_bS_cS_c 3NNNN 4ddLL 8t_ht_ht_mt_m
 - Кодолсон нь: AAMO 44199 0701 19002 666 12121 17001 18301 20102 30045 36293 40503 80300=

ЖИШЭЭ 4: Усны үзэгдлийн мэдээ

Увс аймгийн Хяргас суманд 7 дугаар сарын 20-ны 17 цаг 25 минутанд цаг уурын харуулаас зүүн өмнө зүгт 1км зайд Билүүгийн гол үерлэсэн байна. Дараа өдрийн 12 цаг 45 минутад үер татарсан ба далан сэтэрч урьдчилсан байдлаар 2 сая.төг-ийн хохирол учирсан байна.

- Голын үер /ww=20/-ээр "Аюул" мэдээ K' =1 өгнө. n=1, гол үерлэж эхлэх үед хохирол гарсан эсэх тодорхойгүй байсан тул K_z=4, мэдээнд үзэгдлийн үргэлжилсэн хугацаа өгөөгүй тул $t_w=0$, зүг dd=14, зай /6-р хүснэгт/ LL=00, цаг уурын харуул усны түвшин хэмждэггүй учир 4hhh/ бүлэг өгөхгүй.
 - Код: AAMO llll MMDD T_hT_hT_mT_mn 666 K'K_zt_wWW 4ddLL=
 - Кодолсон нь: AAMO 44839 0720 17251 666 14020 41400=
- 21-ны 12 цаг 45 минутанд үер татарсан тул "Агаар" мэдээ өгнө. хохирол гарсан /1-р хүснэгт/ тул K_z=2, Үзэгдлийн үргэлжилсэн хугацааг /2-р хүснэгт/ хоногоор өгөх тул $t_w=2$, хохирол нь төгрөгөөр гарсан тул /7-р хүснэгт/ z=8, мөнгөн дүн бүхэл оронгоор /8-р хүснэгт/ Ns=3, голын үер нэг сумын нутаг хамарсан тул SaSa=01, нэг багийн нутаг хамарсан SbSb=01, хот айл хамрагдаагүй тул ScSc=00, хохирил дүн 2000000 төг, бүхэл мянгатаар /8-р хүснэгт/ NNNN=2000, зүг dd=14, зай /6-р хүснэгт/ LL=00, үргэлжилсэн хугацаа /2-р хүснэгт/ 2 хоног.
 - Код: AAMO llll MMDD T_hT_hT_mT_mn K'K_zt_wWW 1zN_sS_aS_a 2S_bS_bS_cS_c 3NNNN 4ddLL 8t_ht_ht_mt_m
 - Кодолсон нь: AAMO 44839 0721 12451 666 02220 18301 20100 32000 41400 80002=

2.9. АҮ, БГҮ-ийн мэдээлэл өгөхтэй холбогдсон зарим тайлбар:

а.Болж өнгөрсөн АҮ, БГҮ-ийн талаар орон нутгийн байгууллага, ард иргэдээс авсан "бичвэр" мэдээллийг дамжуулахдаа АҮ, БГҮ-ийн эрч хүч, үргэлжилсэн хугацаа, учирсан хохирол, мэдээлэл өгсөн байгууллага, хүний нэрийг тодорхой тусгана.

б.Хэд хэдэн аюултай үзэгдэл нэгэн зэрэг ажиглагдвал эдгээр үзэгдлийг тус тусд нь "АММО" мэдээ зохиож өгнө. Хэрэв "АММО" мэдээ дамжуулсны дараа өөр АҮ эхэлбэл тэр даруй дахин "АММО" мэдээ зохиож дамжуулна

в."Агаар" мэдээнд үзэгдлийн үргэлжилсэн хугацааг Аюултай болон Онц аюултай үргэлжилсэн хугацаа гэж тус тусад нь гаргаж өгнө.

г. Үзэгдлийн завсарласан хугацаа 15 минут, түүнээс бага бол АҮ, (БГҮ)-ийг үргэлжилсэн гэж үзнэ. Жишээ нь: цасан шуурга 03.10-д эхлээд 04:00–04:15 хүртэл завсарлаад дахин шуурч 08.20-д зогссон бол үргэлжилсэн хугацаа нь 5 цаг 10 минут болно.

д. "АММО" мэдээнд метр(м), метр/секунд (м/с), градус (°C), салхи, алсын бараа зэрэг үг, хэмжлийн нэгж ба бусад нэр томъёог оруулахгүй. Харин бичвэр мэдээнд дээрх нэр томъёог хэрэглэнэ.

2.10. Цаг агаарын АҮ, БГҮ-ийн тухай мэдээллийг өгч, хүлээн авч байгаа бүх өртөө, харуул, ажилтнууд тусгай дэвтэр дээр сар, өдөр, мэдээ өгсөн, авсан цаг, минут, дамжуулсан ба хүлээн авсан хүний нэрийг тодорхой бичиж байна.

Тайлбар: "Цасан шуурга" гэдэг нэр томъёонд алсын барааг 2000м-ээс бага болгон муутгаж байгаа бүх төрлийн (нүдгүй, намын) цасан шуургууд орно. Шуурганы үргэлжилсэн хугацааг нийлүүлж авна.

ГУРАВДУГААР ХЭСЭГ ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН ТУХАЙ ШУУРХАЙ МЭДЭЭЛЭЛ

3.1. Ус, цаг уурын өртөө, харуулын техникч, ажиглагч нар тухайн орон нутагт ой, хээрийн түймэр гарсан тухай мэдмэгц "Аюул", түймэр унтарсан тухай "Агаар", түймрийн эрч хүч, аюул гамшиг ихэсвэл "Онц аюул" мэдээг яаралтай зохиож төвд дамжуулна.

3.2. Түймрийн мэдээнд хэзээ эхэлсэн (өдөр, цаг), ямар түймэр (ойн, хээрийн), түймэр гарсан нутаг өртөө, харуулаас аль зүгт, ямар зайд байгаа болон, аймаг, сум (өртөө, харуул)-ын индексийг өгнө.

3.3. "Агаар" мэдээнд түймэр унтарсан өдөр, цаг, хамарсан нутаг (талбай), учирсан хохирлыг товч тодорхой, дурдана.

3.4. Түймрийн "Онц аюул" мэдээг түймрийн эрч хүч нь ихэсч ойгоос талд, талаас ойд шилжих, хот суурин руу орох, үлэмж их хөрөнгө сүйрэх зэрэг ноцтой байдалд хүрсэн (хүрэхээр болсон) үед өгнө. "Бичвэр" мэдээнд дээр дурдсан ноцтой байдал (аюул, хохирол)-ын талаар тодорхой бичнэ.

ЖИШЭЭ 5: Байгалийн гамшигт үзэгдлийн тухай мэдээ:

Увс аймгийн Өндөрхангай сумаас зүүн хойт зүгт 80км зайтай газарт 5 дугаар сарын 17-ны 17.00 цагийн орчимд ой, хээрийн хавсарсан түймэр гарч, 5000 га орчим бэлчээрийн талбай шатаад байна гэсэн мэдээлэл иржээ. Уг түймэр Зүүнхангай сумын нутгаас орж ирсэн бөгөөд түймрийг 2 өдрийн дараа 19-ний 10 цаг 40 минутын орчимд унтраажээ. Нийт хохирол 6725000 төгрөг, шатсан бэлчээр 15870 га болжээ.

- Мэдээллийг авсан өдөр түймрийн "Аюул" мэдээ өгнө. $n=1$, $K_z=2$ /1-р хүснэгт/, үргэлжилсэн хугацаа өгөөгүй тул $t_w=0$, ой хээрийн хавсарсан түймэр $ww=26$, $z=5$ /7-р хүснэгт/, $N_s=0$ /8-р хүснэгт/, $NNNN=5000$, хоёр сумын нутаг хамарч байгаа тул $S_aS_a=02$, түймэрт өртсөн баг болон хот айл, аж ахуйн нэгжийн тухай мэдээлэл ирээгүй /тодорхойгүй тул/ $S_bS_b=01$, $S_cS_c=00$ гэж өгөх эсвэл $2S_bS_bS_cS_c$ бүлгийг өгөхгүй байж болно. зүг $dd=05$, алслалт $LL=08$.
- Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_m$ 666 $K'K_zt_wWW$ $1zN_sS_aS_a$ $2S_bS_bS_cS_c$ 3NNNN 4ddLL
- Кодолсон нь: AAMO 44191 0517 17001 666 12026 15002 20100 35000 40508=
- Түймэр 19-ний 10 цаг 40 минутад унтарсан тул "Агаар" мэдээ өгнө $K'=0$. хохирол гарсан /1-р хүснэгт/ тул $K_z=2$, Үзэгдлийн үргэлжилсэн хугацааг /2-р хүснэгт/ хоногоор өгсөн тул $t_w=2$, ой, хээрийн хавсарсан түймэр $/ww=26/$, Хохирлын мэдээ өгсөн $/z=5$, $N_s=1$, $NNNN=1587/$, хохиролын мөнгөн дүн 6297000 төг $/z=8$, $N_s=3$, $NNNN=6725/$. хоёр сумын нутаг хамарсан тул $S_aS_a=02$, зүг $dd=05$, зай /6-р хүснэгт/ $LL=06$, үргэлжилсэн хугацаа /2-р хүснэгт/ 5 хоног. т.е: Энэ тохиолдолд бэлчээрийн талбай ба мөнгөн дүнг $1zN_sS_aS_a$ 3NNNN бүлгийг давтан өгнө,
- Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_m$ 666 $K'K_zt_wWW$
 $1zN_sS_aS_a$ $2S_bS_bS_cS_c$ 3NNNN 4ddLL $8t_h t_h t_m t_m$
- Кодолсон нь: AAMO 44191 0519 10401 666 02226 15102 17001 18301 20100 31587 36725 40508 80002=

ЖИШЭЭ 6: Мал, амьтны халдварт өвчний тухай мэдээ:

Увс аймгийн Бөхмөрөн суманд цаг уурын харуулаас зүүн хойт зүгт 60км зайд 8 дугаар сарын 11-ний 08 цагт 30 минутад 2 хот айлын 125 мал боомоор өвчилсөн мэдээ иржээ. 8-р сарын 15-ны 10 цаг 00 минутад өвчний халдварлалтыг бүрэн таслан зогсоосон ба дээрх 2 хот айлын 125 малаас 45 мал үхэж, нийтдээ 6297000 төгрөгийн хохирол гарсан байв.

- 11-ны 08 цаг 30 минутад өвчин гарсан тул "Аюул" мэдээ $K'=1$ өгнө. $n=1$, хохирол гарсан тодорхойгүй /1-р хүснэгт/ тул $K_z=4$, мэдээнд үзэгдлийн үргэлжилсэн хугацаа өгөөгүй тул $t_w=0$, Боом өвчин $/ww=35/$, нэг сумын нутаг хамарсан тул $S_aS_a=01$, нэг багийн нутаг хамарсан $S_bS_b=01$, 2 хот айл тул $S_cS_c=02$, халдвар авсан малын тоо 125 $/z=1$, $N_s=0$, $NNNN=0125/$ зүг $dd=05$, зай /6-р хүснэгт/ $LL=06$,
- Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_m$ 666 $K'K_zt_wWW$ $1zN_sS_aS_a$ $2S_bS_bS_cS_c$ 3NNNN 4ddLL
- Кодолсон нь: AAMO 44826 0811 08301 666 12035 11001 20102 30125 40506=
- 8-р сарын 15-ны 20 цаг 00 минутад өвчний халдварлалтыг бүрэн таслан зогсоосон тул "Агаар" мэдээ $K'=0$ өгнө. хохирол гарсан /1-р хүснэгт/ тул $K_z=2$, Үзэгдлийн үргэлжилсэн хугацааг /2-р хүснэгт/ хоногоор өгсөн тул $t_w=2$, Боом өвчин $/ww=35/$, Хохирлын мэдээ өгсөн $/z=7$, $N_s=0$, $NNNN=0045/$, хохиролын мөнгөн дүн 6297000 төг $/z=8$, $N_s=3$, $NNNN=6297/$. нэг сумын нутаг хамарсан тул $S_aS_a=01$, нэг багийн нутаг хамарсан $S_bS_b=01$, 2 хот айл тул $S_cS_c=02$, зүг $dd=05$, зай /6-р хүснэгт/ $LL=06$, үргэлжилсэн хугацаа /2-р хүснэгт/ 5 хоног. т.е: Энэ тохиолдолд малын тоо ба мөнгөн дүнг $1zN_sS_aS_a$ 3NNNN бүлгийг давтан өгнө,
- Код: AAMO Iliii MMDD $T_hT_hT_mT_m$ $K'K_zt_wWW$ $1zN_sS_aS_a$ $2S_bS_bS_cS_c$ 3NNNN 4ddLL $8t_h t_h t_m t_m$ =
- Кодолсон нь: AAMO 44826 0815 20001 666 02235 17001 18301 20100 30045 36297 40506 80005=

А. ҮЗЭГДЭЛ ЭХЭЛСЭН ТУХАЙД НЬ ӨГӨХ МЭДЭЭЛЭЛ

Үзэгдлийн нэр	Мэдээлэл өгөх үзэгдлийн эрч хүчний хязгаар				Мэдээнд заавал тусгах зүйл	
	"Аюул"	"Давтан аюул"	"Онц аюул"	"Агаар"	Бүх төрлийн "Аюул"	"Агаар"
1	2	3	4	5	6	7
1.Салхи	15 м/с ба түүнээс их болмогц	20, 25 м/с болох тухай бүр	28, 34 ¹ м/с ба түүнээс их болох тухай бүр	10 м/с-ээс бага болоход	Салхины зүг, дундаж хурд	Салхины зүг, хурд, 15 м/с ба түүнээс их хурдтай (аюултай) салхины үргэлжлэх хугацаа (цаг. мин)
2.Цасан ба шороон шуурга ²	Алсын барааны 2000 м-ийн тэмдэгт харагдахгүй болмогц	Алсын барааны 500м-ийн тэмдэгт харагдахгүй болмогц	Алсын барааны 50 м-ийн тэмдэгт харагдахгүй болмогц	Алсын бараа-ны 2000 м-ийн тэмдэгт харагдмагц	Алсын бараа, салхины зүг, хурд	Цасан ба шороон шуурганы үргэлжилсэн хугацаа, алсын бараа
3.Орон шуурга	Орон шуурга / салхины хурд 8м/с* ба түүнээс их болсон тохиолдолд/	Алсын барааны 500 м-ийн тэмдэгт харагдахгүй болмогц	Алсын барааны 50 м-ийн тэмдэгт харагдахгүй болмогц	Шуурга зогсоход	Салхины зүг, хурд, /боломжтой бол алсын бараа/	Шуурга үргэлжилсэн хугацаа, алсын бараа
4.Цас, бороо	Алсын барааны 1000м-ийн тэмдэгт харагдахгүй болмогц	Алсын барааны 500м-ийн тэмдэгт харагдахгүй болмогц	-	Алсын бараа 1000м ба түүнээс их болоход	Алсын бараа	Алсын бараа, үргэлжилсэн хугацаа
5.Нойтон цас	Агаарын температур 0°C ба түүнээс дулаан байхад цас орж эхэлмэгц	-	-	Зогссон тухайд нь	Агаарын температур	Цас үргэлжилсэн хугацаа
6.Цанталт, мөстөлт	Цахилгаан болон холбооны шугаман дээр 5 мм-ээс зузаан шаваас үүсэхэд	10,15, 20, 25, 30 мм-ээс их болох тухай бүр	35 мм-ээс зузаан болоход	Бүрэн хайлж дуусахад	Цанталт, мөстөлтийн зузаан, агаарын температур	Цанталт, мөстөлтийн хамгийн их зузаан, үргэлжилсэн хугацаа
7.Агаарын даралтын бууралт	Сүүлийн 3 цагт 5 гПа ба түүнээс ихээр буурахад	Цаашдаа 3 цагийн дотор нэмж 5 гПа ба түүнээс ихээр буурахад	Сүүлийн 3 цагийн дотор 10 гПа ба түүнээс ихээр буурахад	Даралт өсөж эхэлмэгц	Даралтын 3 цаг тутмын буурал-тын хэмжээ	"Аюул", "Агаар" мэдээ өгөх хугацаанд даралтын нийт бууралтын хэмжээ
8.Хуурайшил	14 цагийн агаарын харьцангуй чийг 30% ба түүнээс бага өдөр дараалан	6 дахь хоног ба цаашид 3 хоног тутамд	15 дахь хоног ба цаашид 3 хоног тутамд	Дараалсан 2 өдрийн 14.00 цагийн харьцангуй чийг 30%-айс их болох	Харьцангуй чийгийн дундаж ⁴ үргэлжилсэн өдрийн тоо	Харьцангуй чийгийн 14 цагийн дундаж ⁴ үргэлжилсэн өдрийн тоо (VI –VIII сард)

1	2	3	4	5	6	7
	3 хоног үргэлжлэхэд					
9. Зузаан цас	Цасны хээрийн хэмжилтээр ой, хээрийн бүсэд 30см, хээрийн бүсэд 26см, Алтайн уулс, говийн бүсэд 20 см зузаан цасан бүрхүүлтэй болоход	-	-	Цасны зузаан заасан хэмжээнээс бага болоход	Цасны хээрийн хэмжилтийн дундаж зузаан, нягт	Цасны хээрийн хэмжилтийн дундаж зузаан, нягт, үргэлжилсэн хугацаа (хоногоор)
10. Үер ⁵	Голын ус үерийн аюултай түвшинд хүрэхэд	Үерийн аюул-тай түвшинээс 5,10,15 см-ээр нэмэгдэж өсөх бүрт	Үерийн аюултай түвшинээс 20 см ба түүнээс ихээр давахад	Голын ус үерийн түвш-нээс доош буурахад	Усны түвшин	Усны түвшин, үргэлжилсэн хугацаа /хоногоор/
11. Мал, амьтны гоц халдварт өвчин ⁵	Гарсан тухай бүрт	-	-	Өвчний халдварлалтыг таслан зогсоосон үед	Өвчний болон газар нутгийн нэрс, үхсэн, халдвар авсан мал, амьтны тоо	Өвчний болон газар нутгийн нэрс, тархалт, үхсэн мал, амьтны тоо, бусад хохирол
12. Ургамлын өвчин, хортон ⁵	Гэнэт дэлгэрч гарах, тархах, нүүдэллэх бүрт	-	-	Хор хөнөөл нь нэмэгдэхгүй болсон үе	Хортон ба газар нутгийн нэр, тархалт, хохирол	Хортон ба газар нутгийн нэр, тархалт, хохирол

Тайлбар: * Салхины хурд 8м/с-ээс бага үед ч Орон шуурганы ажиглалтыг XIV зааврын дагуу ажиглаж АК-01 кодын дагуу дамжуулна.

Б. ҮЗЭГДЭЛ ЗОГССОН ТУХАЙД НЬ ӨГӨХ МЭЭДЭЭЛЭЛ

Үзэгдлийн нэр	“Аюул” мэдээ өгөх үзэгдлийн эрчмийн хязгаар	“Аюул” мэдээнд үзэгдлийн талаар заавал тусгах зүйл	Мэдээ зохиох нөхцөл, хугацаа
1.Мөндөр	Ороод зогсмогц	Мөндөр эхэлсэн, үргэлжилсэн хугацаа, мөндрийн голч, зогсох үеийн агаарын температур	Мөндөр орсон тухай бүр
2.Уруйн үер ⁵	Болоод зогсмогц	Уруйн үер эхэлсэн, үргэлжилсэн хугацаа, хаана болсон, орсон тунадасны хэмжээ	Уруйн үер болсон тухай бүр
3.Нөөлөг салхи / СВ үүлтэй үед/	Болоод зогсмогц /15 м/с ба түүнээс их/**	Нөөлөг эхэлсэн, үргэлжилсэн хугацаа, салхины зүг, хурд	Нөөлөг салхи болсон тухай бүр
4.Өнгөтэй тунадас ³	Ороод зогсмогц	Өнгөтэй тунадас орж эхэлсэн, үргэлжилсэн хугацаа, тунадасны хэмжээ, өнгө ³	Өнгөтэй тунадас орсон тухай бүр
5.Хүйтэн бороо	Бороо 1 цагаас илүүгүй завсарлага-тайгаар 8 цагаас дээш хугацаатайгаар үргэлжлэн орж, энэ хугацаанд салхигүй, агаарын температур 10°C-аас доош, эсвэл 4м/с-ээс их салхитай, агаарын температур 15°C-аас доош байсан үед	Борооны үргэлжилсэн хугацаа, бороотой үеийн салхины дундаж хурд, бороотой байх үеийн хамгийн бага температур	Нөхцөл бүрдсэн үед
6.Уулын цас мөсний нуралт ⁵	Болсон тухайд нь	Хаана болсон, үргэлжилсэн хугацаа, хохирол гарсан эсэх	Болсон тухай бүр
7.Ширүүн аадар бороо	Аадар бороо орсноос 30мм ба түүнээс их тунадас орвол	Аадар бороо эхэлсэн, үргэлжилсэн хугацаа, тунадасны хэмжээ	Тухай үед нь
8.Догшин хуй (Хар салхи)	Болсон тухайд нь	Салхи эхэлсэн, үргэлжилсэн хугацаа, салхины их хурд, өртөө, харуулаас аль зүгт, хэдэн км-т	Болсон тухай бүр нь
9.Газар хөдлөл	Газар хөдлөөд дуусмагц	Яаж мэдрэгдсэн, хохирол	Газар хөдөлсөн тухай бүр

Тайлбар: ⁵ Нөөлөг салхины ажиглалтыг XIV зааврын дагуу ажиглаж АК-01 кодын дагуу дамжуулна.

ХАВСРАЛТЫН ТАЙЛБАР

*1 Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Өмнөговь, Дорноговь, Дундговийн нутаг, Өвөрхангай, Баянхонгорын өмнөд хэсгээр.

*2 Шөнийн цагт алсын барааг харгалзахгүйгээр намын болон нүдгүй цасан шуурга, орон шуурга, шороон шуурга шуурахад "Аюул" мэдээ өгнө. Цасан ба шороон шуурга зогсоход "Агаар" мэдээ өгнө. Багажаар хараа тодорхойлдог газрууд цасан ба шороон шуургаар шөнийн цагт "Аюул", "Агаар" өгөхдөө гэрэлтэй үед /өдрийн цагт/ "Аюул", "Агаар" өгөх зааврын дагуу кодолно.

*3 Өнгөтэй тунадас орсон үед 1л тунадасны дээж авч БОХЗТЛ-т шинжилгээнд явуулна.

Жич: Өртөө, харуулаас алс зайд болсон үзэгдлийн хаана болсоныг зүг /аль зүгт/, алслалт /хир хол зайд/-аар зааж өгнө. Дэлгэрэнгүй мэдээллийг "бичвэр"—ээр /цаасан ба электрон хэлбэрээр/ өгч болно.

*4 Хамгийн бага харьцангуй чийгийн /14 цагийн/ дундаж утга.

*5 Хавсралт "А"-гийн 10, 11, 12, "Б"-гийн 2, 6 —д заасан үзэгдэл ихэвчлэн өртөө, харуул дээр болохгүй, байгалийн гамшигт үзэгдэл гэгдэх тул 2 дугаар хэсгээр мэдээлнэ.

Харин усны үер, уруйн үерийн аюул өртөө, харуул дээр болсон бол усны түвшин, хур тунадасны хэмжээг 1 дүгээр хэсэгт өгнө.

---oOo---